

## ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ .....	4
1.2 Жонш баяжуулах технологи .....	4
1.2.1 Хүдэр бэлтгэх үе шат.....	5
1.2.2 Бутлах ангилах процесс:.....	5
1.2.3 Нунтаглан ангилах процесс .....	5
1.2.4 Хөвүүлэн баяжуулах процесс .....	5
1.2 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал .....	8
1.3 Баяжуулах үйлдвэрийн ажлын горим .....	9
1.4 Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж.....	9
1.4.1 Хүдэр буталж, шигших процессын тоног төхөөрөмж.....	9
1.4.2 Хүдэр нунтаглах, ангилах процессын тоног төхөөрөмж.....	10
1.4.3 Хүдэр баяжуулах процессын тоног төхөөрөмж.....	11
1.5 Усан хангамж .....	12
1.6 Цахилгаан хангамж.....	12
1.7 Үйлдвэрийн барилга байгууламж.....	13
1.8 Хаягдлын аж ахуй .....	13
ХОЕР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	16
2.1 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл .....	16
2.2 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах арилгах зөвлөмжүүд .....	19
ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	21
3.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	24
3.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	25
3.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....	25
3.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	25
3.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	26
3.7 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	27
3.8 БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
3.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	30
3.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	30
ДҮГНЭЛТ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ .....	<b>Error! Bookmark not defined.</b>

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш  
боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Хүснэгт 1 Талбайн солбилцол .....	4
Хүснэгт 2 2023 онд хэрэглэгдэх химийн бодисын хэмжээ .....	6
Хүснэгт 3 Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс .....	8
Хүснэгт 4 Бүтээгдэхүүний гаргалт .....	8
Хүснэгт 5 Ажиллах горим .....	9
Хүснэгт 6 Хүдэр хүлээн авах бункерийн үзүүлэлт .....	9
Хүснэгт 7 Чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт .....	9
Хүснэгт 8 Хацарт бутлуурын техникийн үзүүлэлтүүд .....	10
Хүснэгт 9 Доргиурт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт .....	10
Хүснэгт 10 ВС ND500 маркийн туузан дамжуулагчийн техникийн үзүүлэлтүүд .....	10
Хүснэгт 11 Бөмбөлөгт тээрэмийн техникийн үзүүлэлт .....	10
Хүснэгт 12 Мушгиа ангилагчийн техникийн үзүүлэлт .....	11
Хүснэгт 13 Флотомашинны техникийн үзүүлэлт .....	11
Хүснэгт 14 Өтгөрүүлэгчийн техникийн үзүүлэлт .....	11
Хүснэгт 15 Нийт усны хэрэглээ .....	12
Хүснэгт 16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....	22
Хүснэгт 17 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	25
Хүснэгт 18 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	26
Хүснэгт 19 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	27
Хүснэгт 20 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	28
Хүснэгт 21 БОМТ-ий хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь .....	30
Хүснэгт 22 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	31

**Зургийн жагсаалт:**

Зураг 1 “ГААС” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрийн байршил .....	4
Зураг 2 Баяжуулах үйлдвэрийн тоо-чанарын схем .....	7
Зураг 3 Баяжуулах үйлдвэрийн ус-шлагын схем .....	8
Зураг 4 Хаягдлын сангийн зураг .....	14

## **ОРШИЛ**

Зорилго: “ГААС” ХХК -ийн Хайлуур жонш боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ буюу зайлшгүй хийж гүйцэтгэх ажлыг төлөвлөхөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө оршино.

“ГААС” ХХК -ийн Хайлуур жонш боловсруулах үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **11590.0 мян.төг** зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

### ***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт***

Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт нь дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд:

- Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
- Байгаль орчны төлөв байдалд хяналт тавих хугацаа, хариуцах эзэнг тогтоох,
- Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох,
- Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

“ГААС” ХХК-ийн 2023 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**


**НЭГ. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Төслийн нэр: Хайлуур жонш боловсруулах үйлдвэр  
Төсөл хэрэгжүүлэгч: “ГААС” ХХК  
Улсын бүртгэлийн дугаар: 9011281017  
Регистрийн дугаар: 5460816  
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 12-р хороо, 1-р хороолол, 103-09 тоот. Б.Адарсүрэн Утас: 99110835  
Төслийн байршил: Дорноговь аймгийг Даланжаргалан сумын Олон Овоот багийн нутаг дэвсгэрт байрлах MV-017256 тусгай зөвшөөрөл бүхий 15 га талбайд хэрэгжинэ. Улаанбаатар хотоос зүүн урагш 340 км, Олон овоот төмөр замын өртөөнөөс 2 км зайд оршино.

Талбайн солбилцолууд:

*Хүснэгт 1 Талбайн солбилцол*

	Урграг	Өргөрөг
1-р цэг	108 55 34,03	45 57 17,48
2-р цэг	108 55 37,75	45 57 26,83
3-р цэг	108 56 00,10	45 57 22,50
4-р цэг	108 55 56,10	45 57 13,15



*Зураг 1 “ГААС” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрийн байршил*

“ГААС” ХХК нь анх 2011 оноос дотоод, гадаад худалдааны чиглэлээр байгуулагдсан. Одоо тус компани Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших 10 га талбайд “Хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэр”-т ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна. Монгол орны ихэнх ордуудын үйлдвэрлэлийн ач холбогдолтой жоншны хүдэр нь кварц– флюоритийн төрөлд хамрагддаг, ашигтай эрдэс нь CaF<sub>2</sub> байгаа ба флюоритийн багагүй агуулгатай, өнгөгүй, цөөн тохиолдолд ногоон ягаан өнгөтэй карбонатын маш бага агуулгатай, хорт хольц болох сульфид, фосфор бага байдаг учир өндөр чанарын пбаяжмал гарган авах боломжтой.

## **“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэр нь 2023 онд СаF2 52.09% агуулгатай 26.3 мян.тн хүдрийг боловсруулан баяжуулж, 97% СаF2-ийн агуулга, 47.5% гарц, 88.45% эрдэс авалттай, 12.49 мян.тн жоншны баяжмал гарган авна.**

Тус компани нь боловсруулалтад оруулах жоншны хүдрээ тус баяжуулах үйлдвэрээс баруун урд зүгт 240 км-т орших Дундговь аймгийн Баянжаргалан сумдын нутагт орших MV004306 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Стандарт Алт Монгол” ХХК-ийн ТӨВ ҮНЭГТ-ийн хайлуур жоншны уурхайгаас 26.3 мян.тн хүдэр авахаар холбогдох гэрээг байгуулсан болно.

### **1.2 Жонш баяжуулах технологи**

“ГААС” ХХК-ний жонш баяжуулах үйлдвэрийн баяжуулалтын технологи нь агуулгаар нь дундажлан бэлтгэсэн хүдрийг хоёр шатлалаар бутлан, 1 шатны бөмбөлөгт тээрэмд 70-75%-ийг -0.074 мм –ийн ангилалыг мушгиа ангилуураар ангилан хөвүүлэн баяжуулах машинд оруулж 1 шатны үндсэн флотацийн баяжуулалт болон хяналт, цэвэрлэгээний флотаци явуулж баяжмалыг 6 шатлалаар цэвэрлэж, өтгөрүүлж, хатаан эцсийн бүтээгдэхүүнийг гаргана. Үйлдвэрийн технологийн хаягдлыг хаягдлын даланд хурааж, даланд тунасан усыг үйлдвэрлэлийн технологийн усаар эргүүлэн ашиглана.

#### **1.2.1 Хүдэр бэлтгэх үе шат**

Баяжуулах үйлдвэр нь жонш олборлогчдоос нийлүүлж буй үйлдвэрийн түүхий эдийг баяжуулах үйлдвэрийн дэргэдэх хүдэр дундажлах талбай төмөр зам, авто тээврээр зөөвөрлөн авчирч, агуулгаас нь хамааран үечлэн овоолго байгуулах замаар хүдрийг дундажлан баяжуулахад бэлтгэж хадгална. Мөн дундажлан холих үедээ хүдрийн бүтцийн чанарыг судална. Карбонат багатай /карбонатын модуль 10-15 хүртэл/ бол флотаци нь силикат натрийн дарагч /депрессор/-ийн хэмжээг ихэсгэснээр сайн явагдана. Харин дунд зэргийн карбонатын агуулгатай /карбонатын модуль 9.9-1.0 хүртэл/ бол хүчтэй дарагч шаардлагатай байдаг.

#### **1.2.2 Бутлах ангилах процесс:**

Хүдэр хүлээн авах бункерээс хүдрийг PE-250x450 маркийн хацарт бутлуурт оруулна. Бутлуурт орох хүдрийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ 350 мм байх ба хацарт бутлуурт бутлагдаж 50-70 мм хэмжээтэй бутлагдан туузан дамжуулагчаар 2-р шатны бутлалтанд орно. Анхан шатны бутлах процессоос гарсан хүдэр нь шигшүүрт шигшигдэн PEX 150x750 маркийн конусан бутлуурт орно. Энэ шатанд дээд тал нь PE 600x75 маркийн конусан бутлуураар бутлагдан  $d_{min}$  нь -15 мм хэмжээтэй бутлагдан нунтаглах хэсгрүү тээвэрлэгдэнэ. Бутлагдсан хүдэр нь дүүргэлтийг нь автоматаар хянах ажиллагаантай бункерт хуримтлагдана.

#### **1.2.3 Нунтаглан ангилах процесс**

Бутлагдсан хүдрийн бункерээс 35<sup>0</sup>-н налуу байрлалтай налуу хоолойгоор дамжуулан жоншны хүдрийг нунтаглалтын процесст оруулж тээрэмдэж нунтаглагдах ажиллагаа явагдана. Бутлагдсан хүдрийг -0.074 мм /70-80%/ ширхэглэлтэй болгохын тулд 1 шатны хяналтын ангилалттай нунтаглалтын схемийг сонгосон. Мушгиа ангилагчийн эргэлтийн ачаалал 150% байна.

#### **1.2.4 Хөвүүлэн баяжуулах процесс**

Баяжуулалтанд бэлэн болсон жоншны хүдрийг 1 үндсэн флотацийн процесст оруулж баяжмалыг 6 шатны цэвэрлэгээний флотацийн тус бүрийн өмнө холигч /агитаци/-ийн ган байрлах бөгөөд энд булингыг химийн урвалжуудтай хольж жигдрүүлэх ажил явагдана. Ингэснээр хүдрийг хөвүүлэн баяжуулалтанд орно.

Баяжуулах үйлдвэрийн жоншны хүдрийг баяжуулалтын технологи нь техникийн, кальцийн сод, силикат натри, шингэн шил, хүхэр хүчлийн хөнгөн цагаан, ТЖК тосны хүчил зэрэг урвалжуудыг ашигласан булингын 22-25<sup>0</sup>C-ийн температурын халаалттай хөвүүлэн баяжуулна. Цэвэрлэх

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

процессийн бүх 6 шатанд урвалжууд нэмж өгнө. 1 тн хүдэрт 0.23кг/тн сод, 0.45 кг/тн шингэн шил хэрэглэнэ. Баяжигдах хугацаа 17 минут үргэлжлэнэ.


Үндсэн флотацийн хаягдал нь хяналтын флотацид орж баяжигдсан завсрын бүтээгдэхүүн ба хаягдал гарах бөгөөд хяналтын дамжлагаас гарсан завсрын бүтээгдэхүүн эргэж үндсэн флотациар дамжин цэвэрлэгээний флотациар орж баяжигдан 38-50%-ийн гарцтай, 80-85%-ийн металл авалттай 95-97% CaF<sub>2</sub>-ийн агуулгатай баяжмалыг гаргана.

Флотацийн баяжуулалтаас гарсан баяжмал нь өтгөрүүлэгчид орон өтгөрч дараа нь филтэрт шүүгдэн 10-15%-ийн чийг агуулсан баяжмал хатаах цехэнд 1%-ийн чийгтэй болтол хатаагдана.

*Хүснэгт 2 2023 онд хэрэглэгдэх химийн бодисын хэмжээ*


Д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Норм	Жилийн хэрэгцээ /тн/	Нэгж үнэ, мян. төг	2019 он	Нийт дүн сая.төг
1	Нийт хүдэр	тн				10000	
2	Гаргах баяжмал	тн				4044	
3	Ган бөмбөлөг	кг/тн	1.5	15	1400.0		21.0
6	Филтэрын шүүлтүүр	м <sup>2</sup> /тн	0.02	0.2	10.0		0.002
8	ЖКТМ	кг/тн	0.45	4.5	3000.0		13.500
9	Сод (NaCO <sub>3</sub> )	кг/тн	0.23	2.3	450.0		1.035
10	Шингэн шил( Na <sub>2</sub> SiO <sub>2</sub> )	кг/тн	0.8	8	430.0		3.44
11	(Al <sub>2</sub> (SO <sub>4</sub> ) <sub>3</sub> ) хүхрийн хүчлийн алюминий	кг/тн	0.3	3	300.0		0.9
12	Полиакриламид	кг/тн	0.01	0.1	2000.0		0.2
15	<b>Нийт материалын зардлын дүн</b>	<b>сая төг</b>					<b>40.077</b>

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



Зураг 2 Баяжуулах үйлдвэрийн тоо-чанарын схем

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**



**Зураг 3 Баяжуулах үйлдвэрийн ус-шамын схем**

**Хүснэгт 3 Баяжуулалтын бүтээгдэхүүний баланс**

Бүтээгдэхүүний нэр	Бүтээгдэхүүний гарц, %	CaF <sub>2</sub> -н агуулга, %	CaF <sub>2</sub> -н эрдэс авалт, %
Хаягдал	59.56	12.6	16.0
Баяжмал	40.44	97.0	84.0
Анхдагч хүдэр	100	46.7	100

**Хүснэгт 4 Бүтээгдэхүүний гаргалт**

Бүтээгдэхүүний нэр	Боловсруулах хүдэр			Бүтээгдэхүүний гаргалт					Технологийн хаягдал				
	Хэмжээ, т	Агуулга, %	CaF <sub>2</sub> -н нөөц, т	CaF <sub>2</sub> -н эрдсийн авалт, %	Бүтээгдэхүүний гарц, %	Бүтээгдэхүүний хэмжээ, т	Бүтээгдэхүүний дундаж агуулга, %	Баямал дахь эрдсийн хэмжээ, т	Хаягдлын эрдсийн авалт, %	Хаягдлын гарц, %	Хаягдлын хэмжээ, т	Хаягдлын дундаж агуулга, %	Хаягдал дахь эрдсийн хэмжээ, т
2019 онд дунджаар													
Хаягдал									16.0	59.56	5956	12.6	750.46
Баяжмал				84.0	40.44	4044	97.0	3922.68					
Анхдагч хүдэр	10000	46.7	4670										

**1.2 Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал**

Жонш баяжуулах үйлдвэр нь хоногт 47.6 тн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд 2023 онд 10000 тн хүдэр боловсруулах төлөвлөгөөтэй байна.

Баяжуулах үйлдвэр нь бутлалт, нунтаглалтын цех, флотацийн технологи, 70 гаруй ажиллагсадтай, хагас автоматчлагдсан иж бүрэн, орчин үеийн тоног төхөөрөмжтэй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай зэрэг давуу талуудтай байна. Баяжуулах үйлдвэр нь:

- Хүдэр хүлээн авч дундажлах хэсэг
- Бутлах хэсэг
- Нунтаглах болон хөвүүлэн баяжуулах хэсэг



**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- Урвалжийн хэсэг
- Шүүн хатаах хэсэг
- Химийн шинжилгээний лаборатори
- Хаягдлын далан, эргэлтийн усан сан зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ

**1.3 Баяжуулах үйлдвэрийн ажлын горим**

Жонш баяжуулах үйлдвэр нь 2023 онд 3 улирал, хавар 4-н сараас өвөл 12-н сар хүртэл тасралтгүй 210 хоног ажиллах бөгөөд өдөрт 2 ээлжээр 8 цагаар ажиллана. Бусад үед засвар үйлчилгээний хийгдэнэ.

*Хүснэгт 5 Ажиллах горим*

№	Үзүүлэлт	Утга
1	Жилд ажиллах сар	7
2	Жилд ажиллах хоног	210
3	Жилд ажиллах цаг	3360
4	Сард ажиллах хоног	30
5	Өдөрт ажиллах цаг	16
6	Цагийн хүчин чадал, тн/цаг	3.3
7	Хоногийн хүчин чадал, тн/хон	47.6
8	Сарын хүчин чадал, тн/сар	380.8
9	Жилийн хүчин чадал, тн/жил	10000
10	Бутлагдсан хүдрийн нөөцлөх хоног	1
11	Бутлагдсан хүдрийн нөөцийн хэмжээ, тн	135

**1.4 Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж**

Баяжуулах үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж нь БНХАУ-д үйлдвэрлэсэн орчин үеийн хөдөлмөрийн бүтээмжтэй ашиглалтын зардал багатай тоног төхөөрөмжүүд байна. Баяжуулах үйлдвэрт эрдэс боловсруулалтын төнөг төхөөрөмжүүд /бутлагч, нунтаглагч, хөөсрүүлэн баяжуулах төхөөрөмж, шүүн хатаагч, насоснууд гэх мэт/ суурилагдана.

**1.4.1 Хүдэр буталж, шигших процессын тоног төхөөрөмж**

Хүдэр буталж, шигших процесст шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжүүд нь хүлээн авах бункер, чичиргээт тэжээгүүр, хацарт бутлуур, доргиурт шигшүүр, туузан дамжуулагч байна.

**1. Хүдэр хүлээн авах бункер**

Хүдэр хүлээн авах бункерийн багтаамж нь баяжуулах үйлдвэрийн хүдэр өгөлт, анхдагч тэжээлийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ, хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадлаас хамаарна.

*Хүснэгт 6 Хүдэр хүлээн авах бункерийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ
1	Хүдэр агуулах хүчин чадал, тн/цаг	20
2	Өргөн, мм	3500
3	Өндөр, мм	2500
4	Амсарын хэмжээ, мм	800
5	Хүдрийн ширхэглэл, мм	350
6	Ашиглагдах тоо	1

**2. Чичиргээт тэжээгүүр**

Чичиргээт тэжээгүүр нь хүдрийг хүлээн авах бункерээс жигд хувиарлан хацарт бутлуурыг тэжээлээр хангана. Баяжуулах үйлдвэрт ашиглах GZD-180x180 маркийн чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлтийг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт 7 Чичиргээт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ
1	Загвар:	GZD-180x80
2	Хамгийн том ширхэглэлийн хэмжээ, мм	350
3	Хүчин чадал, тн/цаг	30-80
4	Хөдөлгүүрийн чадал, квт	2 x 1.5

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**


5	Сууриллагдах налуу, градус	0-10	
6	Жин, кг	800	
7	Тавцангийн хэмжээ, мм	1800 x 800	

**3. Хацарт бутлуур**

Баяжуулах үйлдвэрийн анхан шатны бутлалтанд хацарт бутлуурыг ашиглана. Хацарт бутлуур нь тэжээгүүрээр дамжин 350 мм-ийн хүдрийг 50-75мм хүртэл бутлана. 2-р шатны бутлалтанд мөн адил хацарт бутлуур хэрэглэнэ. Хүдэр бутлалтанд ашиглах хацарт бутлууруудын техникийн үзүүлэлтийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

*Хүснэгт 8 Хацарт бутлуурын техникийн үзүүлэлтүүд*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ	
		PE 250x450	PE 150x250
1	Загвар:		
2	Бутлагдах хүдрийн хамгийн том ширхэглэл, мм	350	125
3	Асгах завсрын өргөн, мм	40-100	15-45
4	Бүтээмж, тн/цаг	25-64	15-25
5	Хөдөлгүүрийн хүчин чадал, квт	30	5.5
6	Хөдөлгүүрийн эргэлтийн хурд, эрг/мин	300	250




**4. Доргиурт шигшүүр**

Доргиурт шигшүүр нь хацарт бутлуурт бутлагдсан хүдрийг 15 мм-ийн ангилалаар шигшиж ангилах үүрэгтэй ажиллана. Доргиурт шигшүүрийг шүүрийн доорх бүтээгдэхүүн нь бутласан хүдрийн бункерт туузан дамжуулагчаар дамжин орно. Шигшүүрийн дээрх 15мм-ээс дээших бүтээгдэхүүн нь 2-р шатны хацарт бутлуурт орж бутлагдана.

*Хүснэгт 9 Доргиурт тэжээгүүрийн техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ
1	Загвар:	YA1237
2	Шигшүүрийн хэмжээ, мм	1200 x 3000
3	Тавцангийн давхрага, ш	1
4	Торны нүхний хэмжээ,мм	15
5	Бүтээл, тн/цаг	7.5-70
6	Хөдөлгүүрийн хүчин чадал, квт	5.5
7	Шигших талбай, м <sup>2</sup>	4.44



**5. Туузан дамжуулагч**

Хүдэр бэлтгэх цехийн дотоод тээвэрлэлтэнд туузан дамжуулагчийг ашиглах бөгөөд уг цехэд 4 ширхэг туузан дамжуулагч ашиглагдана. Туузан дамжуулагчийн хамгийн том ширхэглэлийн хэмжээ 75 мм, бүтээмж нь 35, 80.97, 80.97 тн/цаг байна.

*Хүснэгт 10 BC ND500 маркийн туузан дамжуулагчийн техникийн үзүүлэлтүүд*

Үндсэн үзүүлэлтүүд	Конвейерүүд			
	1	2	3	4
Туузны өргө, мм	500	500	500	500
Конвейерийн урт, мм	32	30	35	35
Хөдөлгүүрийн хүчин чадал, квт	5.5	5.5	5.5	12
Барабаны диаметр, мм	500	500	500	500
Шугаман хурд, м/сек	1.1	1.1	1.1	1.1

**1.4.2 Хүдэр нунтаглах, ангилах процессын тоног төхөөрөмж**

Хүдэр нунтаглаж ангилахад ган бөмбөлөгт тээрэм мушгиа ангилагч зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглана.


**1. Бөмбөлөгт тээрэм**

Бөмбөлөгт тээрэм нь бутлагдаж бэлтгэгдсэн 15 мм-ээс дооших ангилалын материалыг нунтаглаж мушгиа ангилуурт өгнө.

*Хүснэгт 11 Бөмбөлөгт тээрэмийн техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ
1	Загвара:	MQ 1500x7500
2	Диаметр	1500


**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3	Их биеийн техникийн үзүүлэлт, мм	Урт	7500	
4	Их биеийн эргэлтийн хурд, эрг/мин		26	
5	Тэжээлийн ширхэглэл, мм		<=25	
6	Гаргах материалын ширхэглэл, мм		0.074-0.147	
7	Хүчин чадал, тн/цаг		2.81-20	
8	Хөдөлгүүрийн чадал, квт		90	

**2. Мушгиа ангилагч**

Мушгиа ангилагчид орж байгаа хүдрийн хэмжээ 15.19 тн/цаг байгаа бөгөөд доорх ангилагчийг сонгон авсан.

*Хүснэгт 12 Мушгиа ангилагчийн техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ	
1	Загвар:	FLG-300	
2	Спиралын диаметр, мм	300	
3	Спиралын эргэлтийн хурд, эрг/мин	8	
4	Бүтээл, тн/цаг	10-80	
5	Ангилагчийн налуу, град	14-18	
6	Хөдөлгүүрийн марк	Y132S-6	
7	Хөдөлгүүрийн хүчин чадал, квт	12	


**1.4.3 Хүдэр баяжуулах процессын тоног төхөөрөмж**

Жоншны хүдэр баяжуулах технологийн процесст үндсэн баяжуулалтын флотомашин, хяналтын флотомашин, цэвэрлэгээний баяжуулалтын флотомашинууд, урвалж тохируулагч, холих гангууд, зутангийн насос зэрэг тоног төхөөрөмжүүд ажиллана.

**1. Флотомашин**

Хүдэр баяжуулах үйлдвэрийн флотацийн баяжуулалтыг үндсэн, цэвэрлэгээний болон хяналтын флотомашинуудад гүйцэтгэнэ.

*Хүснэгт 13 Флотомашинны техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ		
1	Флотоцийн шат	Үндсэн болон хяналт	Цэвэрлэгээний	
2	Чанны эзэлхүүн, м <sup>3</sup>	2.8	1.1	
3	Импеллерын диаметр, мм	600	500	
4	Бүтээмж, м <sup>3</sup> /мин	0.4-2	0.12-0.28	
5	Импеллерын эргэлтийн хурд, эрг/мин	247	500	
6	Хөөс хамагчийн эргэлтийн хурд, эрг/мин	-	17.5	
7	Импеллерын хөдөлгүүрийн марк	Y90S-4	Y80M-4	
8	Импеллерын хөдөлгүүрийн хүчин чадал, квт	1.1	1.1	
9	Овор хэмжээ, мм	1300	2625	
	- Урт	1300	1130	
	- Өргөн	1250	1290	
	- Өндөр			
10	Жин, кг/чанн	1479	410	


**2. Өтгөрүүлэгч**

Хүдэр баяжуулах үйлдвэрийн эцсийн шат дамжлага болох усгүйжүүлэх хэсгийн эхний ажиллагаа бол өтгөрүүлэлт бөгөөд флотациас гаргасан баяжмалыг усгүйжүүлнэ. Өтгөрүүлэгчид орох хүдрийн хэмжээ 3.6 тн/хон бөгөөд дээрх өгөгдлийг хангаж чадах өтгөрүүлэгчийг сонгон авлаа.

*Хүснэгт 14 Өтгөрүүлэгчийн техникийн үзүүлэлт*

№	Үндсэн үзүүлэлтүүд	Тоо хэмжээ
	Өтгөрүүлэгчийн диаметр, мм	NZSG-3.6
	Өтгөрүүлэгчийн гүн, мм	1800
	Өтгөрүүлэх талбай, м <sup>2</sup>	10.2

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

	Эргэлтийн хурд, эрг/мин	0.4	
	Цахилгаан хөдөлгүүрийн загвар	Y90L-6-1.1/910	
	Бүтээмж, тн/цаг	5-24	

### 1.5 Усан хангамж

2023 онд 26,300 тн хүдэр боловсруулан баяжуулахад үйлдвэрлэлд нийт 64,403.5 м<sup>3</sup> ус хэрэглэнэ. Үйлдвэрийн талбайд өөрийн өрөмдсөн 3 ш гүний худагтай. Баяжуулах технологид шаардлагатай усны ундарга нь 1.15 л/сек бөгөөд үйлдвэрийн усны хэрэглээг бүрэн хангах боломжтой.

#### Үйлдвэрийн усан хангамж

Баяжуулах үйлдвэрт хэрэглэгдэх нийт усны хэрэглээг дараах зориулалтаар ашиглана. Үүнд:

**А) Ахуйн болон ундны хэрэглээний усан хангамж:** Унд ахуйн хэрэглээний усыг өөрийн өрөмдсөн худгаас хангах ба тус баяжуулах үйлдвэр нь 64 ажиллагсадтай, хоногт хэрэглэх усны хэмжээ нь хоногт 22 м<sup>3</sup>, жилд 3306.2 м<sup>3</sup> ус хэрэглэнэ.

**Б) Технологийн усан хангамж:** Технологийн усан хангамжид нийт 64,403.5 м<sup>3</sup> ус хэрэглэх бөгөөд үүний 30% буюу 19,321.1 м<sup>3</sup> нь цэвэр усаар хангагдана.

**В) Эргэлтийн усан хангамж:** Эргэлтийн усан хангамжид хаягдлын усан сангаас буцаж ирэх ус орох бөгөөд нийт 45,082.5 м<sup>3</sup> буюу 70% нь ус эргэлтийн усаар нөхөгдөнө.

**Г) Бусад усан хангамж:** Бусад усан хангамжид жилд 0.2 га талбайг /тарьсан зүлэг, мод болон шимт хөрсийг услах, мөн дулааны улиралд автозамын тоосжилтоос хамгаалах зорилгоор/ услахад 24,413.7 м<sup>3</sup> ус ашиглагдана.

### Усны зарцуулалтын нэгдсэн товчоон

*Хүснэгт 15 Нийт усны хэрэглээ*

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Жилд зарцуулах усны хэмжээ, м <sup>3</sup>
1	Технологийн эргэлтийн усны хэрэгцээ /70%/,	м <sup>3</sup>	45,082.5
2	Нийт технологийн ус нэмж сэлбэх хэрэгцээ /30%/,	м <sup>3</sup>	19,321.1
3	Ахуйн болон ундны усны хэрэгцээ	м <sup>3</sup>	3,306.2
4	Бусад усны хэрэгцээ	м <sup>3</sup>	24,413.7
5	<b>Нийт усны хэрэгцээ</b>	<b>м<sup>3</sup></b>	<b>92,123.5</b>

### 1.6 Цахилгаан хангамж

#### 1. Үйлдвэрийн гадаад цахилгаан хангамж

Жонш баяжуулах үйлдвэрт суурилагдсан тоног төхөөрөмжийн суурь чадал технологийн ажиллагаа нь цахилгаан эрчим хүчний гол хэрэглэгч байна.

Цахилгааны эх үүсвэрийг баяжуулах үйлдвэрээс 3 км-ийн зайд орших Даланжаргалан сумын төвийн 35 квт-ын өндөр хүчдлийн шугамаас 3 км-ийн урттай шугам татаж, трансформатороор бууруулан татаж хангасан.

#### 2. Дотоод цахилгаан хангамж

Үйлдвэрийн цахилгааны гол хэрэглэгчид нь жонш бутлах цех, хөвүүлэн баяжуулах цех, засварын цех, тосгон зэрэг болно.

## **“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Жонш баяжуулах үйлдвэрийн технологийн шугамд хацарт бутлуур, доргиурт шигшүүр, бөөрөнцөгт тээрэм, туузан зөөгүүр, мушгиа ангиуур, флотацийн машинууд, хатаагч, савлагч төхөөрөмжүүд зэрэг цахилгаан хэрэглэгчид, мөн түүнчлэн ажилчдын байр, хоолны газар, засварын газар, зэрэг цахилгаан хэрэглэгчид нь 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдах шаардлагатай.

Үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид нь дээрх 35/0.4 кВ-ын трансформаторын дэд станцаас нам хүчдэлийн кабелиудаар тэжээгдсэн цахилгаан хангамжтай байхаар тусгав. Тосгон нь 0.4 кв-ын тусдаа татсан бага чадлын трансформатораас тэжээгдэнэ.

### **1.7 Үйлдвэрийн барилга байгууламж**

Жонш баяжуулах үйлдвэр нь хүдэр нөөцлөх талбайтай автозамаар холбогдоно. Баяжуулах үйлдвэрийн хойд талд хүдрийн агуулахын талбай, баруун урд талд хаягдлын далан байрлана. Үйлдвэрийн барилга нь галерейгаар холбогдсон бутлах цехийн 2 корпус, төв корпус шүүн-хатаах цех, баяжмал савлах, туслах корпус бэлэн бүтээгдэхүүн хадгалах агуулах, үйлдвэрийн дэргэд лабораторийн барилга гэх мэт барилга байгууламжаас бүрдэнэ.

### **Холбооны байгууламж**

Үйлдвэрийн тосгон нь Мобиком, Скайтел зэрэг үүрэн холбооны сүлжээ холбогдсон дэд бүтэц утсан холбоо сайн хөгжсөн газар байрладаг. Тосгон, баяжуулах үйлдвэрийн үндсэн байрлалууд дээрх операторууд, дугуйт ачигч, автосамосвал зэрэг үндсэн тоног төхөөрөмжийн операторууд, ээлжийн дарга нар богино долгионы радио холбоогоор хангагдана.

Баяжмал тээврийн зам дагуу тодорхой цэгүүдэд болон хилийн дамжуулан ачих цэг дээр радио станцуудыг байрлуулах бөгөөд эдгээр цэгүүд нь үйлдвэр болон Улаанбаатар дахь оффистой холбогдоно. Үйлдвэрийн тосгонд сансарын антенн суурилуулж телевизийн сувгууд хүлээн авна.

### **1.8 Хаягдлын аж ахуй**

#### **1. Баяжуулах үйлвэрээс гарах хаягдал**

Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуй нь үйлдвэрээс зүүн зүгт 0.1 км-зайд байрлана. Баяжуулах үйлдвэрээс гарах нийт хаягдал нь жилд 4.2 мян.тн буюу 2.6 м3, 11.3% ийн технологийн хаягдал гарна. Далангийн нийт урт 120м урт, өргөн 105 м, гүн нь 6 м, нийт эзлэхүүний хэмжээ 75576 м3.



*Зураг 4 Хаягдлын сангийн зураг*

## **2. Хатуу хог хаягдал**

Үйлдвэрийн барилгын ажлаас илүү гарсан бетон зуурмаг, машин техникийн сэлбэг, эд ангийн баглаа боодол, машины дугуй, сольсон хуучин сэлбэг, замын тэмдэглэгээ, тэдгээрийн холбох хэрэгсэл, эрэг боолтын баглаа боодол зэрэг хаягдлууд бий болно.

Ажилчдаас цаас, нийлэг эд материалууд, хөвөн даавуу болон малын яс гэх мэт хүмүүсийн эдэлж хэрэглэсэн янз бүрийн ахуйн хэрэглээний хог хаягдал гарна. Хоногт нэг хүнээс 0.3 кг хатуу хог хаягдал гарна гэж тооцвол нийт 73 хүн х 0.3 кг х ажиллах 210 хоногт буюу жилд 4,6 тн орчим хатуу хог хаягдал гарахаар байна.

Ахуйн хэрэглээнээс гарах хатуу хог хаягдлыг тусгайлан бэлтгэсэн хогийн түр хураах цэг байгуулах бөгөөд тус бүр хураах цэгт таглаа битүүмжлэл бүхий хогийн сав яаралтай байгуулан ашиглах шаардлагатай байгаа. Хог хаягдлын түр цэгийг сонгохдоо салхины зонхилох чиглэлийн доор тогтсон нэг цэгт байгуулж, гарах хатуу хог хаягдлыг тухай бүр ариутгаж, овор хэмжээг нь багасгах зэргээр байгаль орчинд үзүүлэх хор нөлөөг багасгах хэрэгтэй.

## **3. Шингэн хаягдал**

Үйлдвэрийн барилгын ажил болон үйл ажиллагааны үед ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжүүдэд зохих хуваарийн дагуу техникийн үйлчилгээ хийх үед ажилласан тос, тосолгооны хаягдал материал гарахаар байна. Мөн үйл ажиллагаа явагдахын зэрэгцээ ажилчдын зүгээс ахуйн чанартай шингэн хаягдлууд гарна. Үүнд:

- Хоол хүнсний хаягдал
- Цэвэрлэгээнээс гарсан бохир ус
- Бие засах газрын хаягдал зэрэг болно.

Ахуйн хэрэглээний усыг өөрийн өрөмдсөн худгаас хангах ба тус баяжуулах үйлдвэр нь 73 ажиллагсадтай, хоногт хэрэглэх усны хэмжээ нь 10950 л, жилд 1752000 л буюу 1752 м<sup>3</sup>, цайны газрын усны хэрэглээ нь хоногт 7008 л ус, жилд 1121280 л буюу 1121.28 м<sup>3</sup> ус хэрэглэх ба нийтдээ

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

1752+1121.28=2873.28 м<sup>3</sup> ус жилд хэрэглэх тооцоо гарч байна. /БОНХАЖЯ-ны сайдын 2015 оны А/301 тушаалыг үндэслэн тооцов/. Бохир усны хэмжээг цэвэр усны хэмжээний 70% -иар тооцож гаргахад 784.9 м<sup>3</sup> шингэн хаягдал гарахаар байна.

## **ХОЕР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

### **2.1 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл**

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлгээний үндсэн аргуудын тусламжтайгаар илрүүлж олно, Нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэдэхүүнд хүчин зүйлүүд нь нөлөөлөл үзүүлэхгүй тохиолдолд цаашид дэлгэрэнгүй авч үзээгүй болно. Үзүүлэх нөлөөлийг магадлан жагсаалтын аргаар илрүүлэхдээ доор заасан 3 ангилалаар гүйцэтгэв. Үүнд:

“+” - нөлөөлөл үзүүлнэ /дурын нөлөө/

“-” - нөлөөлөл үзүүлэхгүй

“~” - урьдчилан таамаглах боломжгүй, энэ талаар гүйцэд судлагдаагүй

№	Орчны бүрэлдэхүүний үзүүлэлтүүд	Үзүүлэх нөлөөлийг магадлан жагсаалтын аргаар илрүүлэхэд			
		нөлөөлөл үзүүлнэ /дурын нөлөө/	нөлөөлөл үзүүлэхгүй	урьдчилан таамаглах боломжгүй, энэ талаар гүйцэт судлагдаагүй	
1.	Цаг уур, уур амьсгалд	Цаг уур, атмосфер дэх агаарын бохирдол	+		
		Микроцаг уурын өөрчлөлт	+	~	
		Хур тунадас, чийгийн горим	+		
		Чийгшил, хэт чийгшил			~
		Хуурайшилт, хэт хуурайшилт	+	~	~
		Температурын горим			~
		Халалт, хэт халалт	+		~
		Хүйтрэл, хэт хүйтрэл			
2.	Түр хугацааны буюу ашиглалтад өгөхөөс өмнөх үеийн агаарын бохирдол	Салхины хурд, чиглэл			~
		Үйлдвэрийн барилга байгууламжийн угсралт	+		
		Хөрс хуулалт	+		
		Тоосжилтоор	+		
		Химийн хорт бодисоор			~
		Бага зэргийн аюултай бохирдуулагч бодисоор		-	
		Барилга байгууламж барих	+		
		Зам талбай байгуулах үед	+		
		Тоосжилтоор	+		
Химийн хорт бодисоор		-			
3.	Байнгын буюу ашиглалтанд орсны дараах агаарын бохирдол	Бага зэргийн аюултай бохир- дуулагч бодисоор	+		
		Дотоод шаталтат хөдөлгүүрээс ялгарах хийгээр бохирдох	+		
		Үйлдвэрлэлээс гарах химийн хорт бодисоор бохирдох	+		
		Цацраг идэвхит бодисоор бохирдох			~
		Галлагаанаас гарах хийгээр бохирдох		-	
		Ил задгай агаарт хаягдал шатаалтын бүтээгдэхүүнээр бохирдох	+		
		Энерги гарган авах зориулалттай шаталтын бүтээгдэхүүнээр бохирдох		-	
4.	Геологийн орчин	Хүнд металлаар		-	
		Бусад		-	
		Цэвдэгшилийн нөлөө		-	
		Ашигт малтмал		-	
5.	Гадаргын хотойлт	Тектоникийн идэвхижилт			~
		Локаль геобүтцийн өөрчлөлт			~
		Их хэмжээний		-	
		Бага хэмжээний	+		
		Гүнзгий	+		



**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш  
боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		Нам	+	-		
6.	Гадаргын гүдийлт	Их хэмжээний	+			
		Бага хэмжээний	+			
		Гүнзгий			-	
		Нам	+			
7.		Шимт хөрсний алдагдал	+			
8.		Ландшафтын доройтол	+			
9.	Гидро-геологи, газрын доорхи ус	Газрын доорхи буюу хөрсний ус	+			
		Гүний ус	+			
		Усны нөөц багасах	+			
10.	Усны чанар	Усны үндсэн найрлагын харьцаа өөрчлөгдөх		-		
		Эрдэжилт	+			
		Биоидэвхит нэгдлүүдийн харьцаа	+			
		Өөрөө цэвэрших чадвар			-	
		Ксенобиотикоор бохирдох			-	
		Урсгалын чиглэл			-	
		Рельеф, экзоген процесс				~
		Гадаргын ус			~	
11.	Хөрс /	Хөрсний усны горим	+			
		Хөрсөн дэх агаарын горим	+			
		Хөрсний механик бүтэц	+			
		Хөрсний чанар	+			
		Буфер багтаамж	+			
		Хөрсний бохирдол	+			
		Ксенобиотикоор бохирдох	+			
		Өөрөө цэвэрших чадвар			-	
		Хөрсний микрофаун, мезофаун	+			
		Хөрсний макрофаун, мегафаун	+			
		Хөрсний механик элэгдэл	+			
		Зохион байгуулалтгүй ашиглалт	+			
		Антропоген (газар хагалалт)			-	
		Бэлчээрийн талхагдал	+			
		Ойн мод бэлтгэл			-	
12.	Ургамал	Усны ургамал			-	
		Гадаргын ургамал	+			
		Дээд ургамал	+			
		Модлог			-	
		Бутлаг			-	
		Өвслөг			-	
		Ховор	+			
		Ашигтай			-	
		Ерөнхий биотархалт	+			
		Нөөц	+			
		Өөрөө нөхөн сэргэх чадвар	+			
		Доод ургамал	+			
		Ховор	+			
		Ашигтай			-	
		Ерөнхий биотархалт	+			
13.	Амьтан	Сээр нуруутан	+			
		Загас			~	
		Хоёр нутагтан			~	
		Мөлхөгчид	+			
		Шувуу	+			
		Сүүгээр бойжигчид	+			
		Сээр нуруугүйгэн	+			
		Биотархалт	+			
		Шавьж	+			
		Хавч хэлбэртэн			-	
		Аалз хэлбэртэн	+			

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

		Бусад		-	
14.		Тусгай хамгаалалттай нутагдэвсгэр		-	
15.	Хөдөө аж ахуйн үзүүлэлтүүд	Малын-бэлчээр	+		
		Бэлчээрийн чанар	+		
		Бэлчээрийн нөөц	+		
		ХАА-н бүтээгдэхүүний чанар		-	
16.	Нийгэм эдийн засгийн үзүүлэлт	Газар ашиглалт	+		
		Ойр орчмын хүн амжсан суурин	+		
17.	Дэд бүтэц	Цахилгааны хэрэглээ	+		
		Дулааны хэрэглээ	+		
		Холбоо		-	
		Зам	+		
		Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа		-	
18.	Орчны физик параметруудийн өөрчлөлт	Дуу чимээ	+		
		Чичэрхийлэл	+		
		Цахилгаан соронзон орон зай		-	
		Цацраг идэвхижил		-	

Магадлан жагсаалтын арга нь нөлөөллийн орчны бүх бүрэлдэхүүн хэсгүүдээр нөлөөллийг авч үздэгээрээ онцлог боловч нөлөөлөх хүчин зүйлүүд болон нөлөөлд өртөгчтэй харьцах харьцаа, тэдгээрийн хоорондох логик холбоос болон нөлөөллийн хэр хэмжээг харуулж чаддаггүй, бүрэлдэхүүн хэсгүүдээр давхардмал байдлыг харгалзан үздэггүй зэрэг дутагдалтай талуудтай. Эдгээр дутагдалтай талуудыг үгүй болгох, нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөллийн цар хүрээ, хэмжээг тодорхойлохдоо ихэвчлэн Леопольдын матрицын аргыг хэрэглэнэ. Матрицад ашиглагдах нөлөөлөх хүчин зүйл болон нөлөөлөлд өртөгчийг оруулахдаа магадлан жагсаалтыг үндэслэв.

*Матрицын нөлөөлөгч хучин зүйлийг дэлгэрэнгүйгээр авч үзвэл:*

- Үйлдвэрийн технологи дамжлагын явцад бий болгох шуугиан,
- Хүдэр бутлалтаас эхлээд баяжмал гаргаж хүртэлх бүх технологийн дамжлагын явцад бий болгох тоос, тоосонцор
- Хаягдлын далан байгуулахад хөрс хуулах, ачих, зөөхөд үүсэх тоос шороо
- Химийн бодисын хэрэглээ
- Хаягдлын даланд хуримтлагдах хаягдлаас агаарт уурших цагаан тоос
- Үйлдвэрийн газар ашиглалтаас үүсэх газрын элэгдэл, эвдрэл
- Хаягдлын сан
- Үйлдвэрээс гарах хатуу хог хаягдал
- Гүний ус ашиглалт

Дээрхи сүлжээ схемээс үзэхэд тус төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үндсэн хүчин зүйл болох барилга байгууламж барих ажиллагаа, үйлдвэрээс гарах хатуу хог хаягдал, технологийн усны хэрэглээ, химийн бодисын хэрэглээ, түүхий эд тээвэрлэлт зэрэг нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох агаар, гүний ус, газрын хөрс, ургамалд шууд нөлөөлнө. Нөлөөллийн зарим хүчин зүйл нь байгаль орчны өөр хоорондоо салшгүй холбоо бүхий бүрэлдэхүүн хэсгүүдэд шууд байдлаар нөлөөлөхөөр байгаа нь амьд организмын амьдрах орчны хязгаарлалт, тэдний дайжилт, газрын хөрсний эвдрэл, элэгдэл, ургамлын бүлгэмдлийн талхлалт, цөлжилт үүсгэхэд тодорхой хувь нэмэр оруулах бөгөөд байгаль орчны ерөнхий доройтолд хүргэснээр амьд организмын амьдралын үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болохуйц шууд бус үйлчлэл үзүүлэх юм.

Төслийн үндсэн объектүүдээс гадаад орчинд үзүүлэх сөрөг нөлөөллүүд үргэлжлэх хугацааны хувьд хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Тухайлбал хүдэр боловсруулалт, хүдэр тээвэрлэлт зэргээс тоосжилт, хог хаягдлын удаан хадгалалтын явцад гарах үнэр болон тээврийн хэрэгслээс ялгарах хий зэрэг нь байнга үргэлжлэх тул агаарын бохирдол үүсэх юм.

Тус төслийн зүгээс гадаад орчинд үзүүлэх олон төрлийн нөлөөлөл явагдах боломжтой тул эдгээр

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл, бохирдлын эх үүсвэрүүдийг орчны бүрэлдэхүүн хэсгүүдтэй ямар байдлаар харилцан үйлчлэхийг тайлангийн тодорхой бүлгүүдэд авч үзсэн бөгөөд төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тусгасан болно.

**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АРИЛГАХ ЗӨВЛӨМЖҮҮД**

**Газрын гадаргын хөрсний элэгдэл, бохирдлыг багасгах талаар:**

- Үйлдвэрийн барилга байгууламжийг барьж байгуулж дууссаны дараа бусад газрын хөрснийг элэгдэлд өртүүлэхгүйн тулд үйлдвэрийн дотоод замыг хатуу хучилттай болгох
- Түүхий эдийн тэвээрлэлт, бүтээгдэхүүний ачилт буулгалт зэргийг тогтоосон замаар явуулж олон салаа зам гаргахгүй байх
- Үйлдвэрийн ногоон байгууламжийг төлөвлөлтийн дагуу үйлдвэр ашиглалтанд оруулснаас хойш 1-2 жилийн дотор байгуулах
- Хаягдлын санд хаягдах ус хэмжээнээс хэтрүүлэхгүй тогтмол хэмжээнд барих арга хэмжээ авч ойр орчимд тойруулан хатуу хучилттай болгож, гадна талд нь хамгаалах зориулалтыг хаалт, хашаа байгуулах
- Шатах, тослох материалын хадгалалтын горимыг сайн хянан ажиллаж хэрвээ газрын хөрсөнд асгарсан тохиолдолд тухайн газрын хөрсийг саармагжуулан цэвэрлэж, арчлах арга хэмжээ авах
- Үйлдвэрийн хотхоны сул чөлөөтэй газрыг зүлэгжүүлэх
- Үйлдвэрийн ногоон байгууламжийг арчлан, тордон хамгаалах

**Агаарын бохирдлыг багасгах талаар**

- Түүхий эд тээвэрлэх, буулгах, бүтээгдэхүүний ачиж буулгах үед үүсэх тоос, шороог багасгах зорилгоор зам, талбайг байнга услах
- Автотээврийн зогсоолыг замыг хатуу хучилттай болгож ойр орчмыг нь зүлэгжүүлэх
- Үйлдвэрийн гадаад, дотоод орчны агаарын бохирдлыг тогтмол тодорхой хугацаанд хянаж байх
- Химийн бодис хадгалах агуулахыг тусад нь стандартын дагуу байршуулах, химийн бодис ашиглах, тээвэрлэх явцад гадаад орчинд алдагдахаас хамгаалах
- Хог хаягдлын цэгээс ялгарах хий, үнэрийг дарах зорилгоор ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хугацаанд хийж, хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах
- Хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан шинжилгээнүүдийг тогтсон хугацаанд хийлгэх

**Химийн бодисоос үүсэх сөрөг нөлөөлөлийг бууруулах талаар**

- Химийн бодистой харьцах ажиллагсдыг хамгаалалтын иж бүрэн хувцасаар хангах
- Химийн бодисыг хадгалах сав баглаа, боодлын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж ажиллах
- Химийн бодисын агуулахад үйлдвэрийн хотхоноос тусдаа үйлдвэрээс зайтай байршуулах болон зөвхөн хамгаалалтын хувцас хунартай хүнийг агуулахад орж байхыг ажиллагсдад сануулах
- Химийн бодисыг тээвэрлэх тохиолдолд стандартын шаардлага хангасан химийн бодисын сав баглаа, боодлын битүүмж алдагдсан эсэхэд хяналт тавих
- Химийн бодистой харьцах хүмүүст аюулгүй ажиллагааны дүрэм, аюулгүй ажиллагааг заавал дагаж мөрдөх талаар зөвлөмж өгч байх
- Тухайн үйлдвэрийн зүгээс хамгаалалтын хувцасаар байнга хангах
- Химийн бодис асгарсан үед яаралтай сармагжуулах, цэвэрлэж ариутгал хийх

**Усны бохирдол, усны нөөц багасах, хомсдохоос хамгаалах талаар**

- Ундны цэвэр усныг хадгалах сав нь чанарын шаардлага хангасан байх ба удаан хугацаагаар хадгалахгүй 3-4 өдөрт хангах усаа сэлгэж сольж, ахуйн хэрэглээний үлдэгдэл усаар үйлдвэрийн ногоон байгууламжийг услах
- Үйлдвэрийн технологийн ус насосноос алдагдахаас сэргийлэх, бүрэн бүтэн байдлыг байнга хянах, тоног төхөөрөмжийн хуучирсан гэмтэлийг байнга засварлан шинэчилж байх
- Үйлдвэрийн ногоон байгууламжийг агротехникийн дагуу услах
- Үйлдвэрийн худгуудад хамгаалалтын зурвас байгуулах, бохирдоос хамгаалах
- Үйлдвэрийн хатуу хог хаягдлын цэгүүдийг гүний худгийн уст нөлөөлөл үзүүлэхгүй газарт байрлуулан хаалт, хамгаалалт тогтоож хогийг бусад газарт тархахаас хамгаалах

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- Хаягдлын сан орчимд гаргасан хяналтын худгаас тогтмол хугацаанд усны нөөц, болон гүний усны бохирдолын хяналт хийж байх
- Ус ашиглах дүгнэлтийг холбогдох газруудаар гаргуулан ажиллах, шинээр гаргах ашиглалтын худгуудыг усны тоолуураар тооноглон баталгаажуулах, тоолуурын заалтаар усны нөөцийн ашиглалтын төлбөрийг 2013 оны Засгийн газрын “Усны нөөц ашигласны төлбөрийн тухай” 326 болон 327 дугаар тогтоолын дагуу тооцож байх

**Хог хаягдлаас үүсэх сөрөг нөлөөлөлийг бууруулах, арилгах талаар**

- Хатуу хаягдлыг цуглуулах, ангилал, тээвэрлэх, зайлуулах зэрэг үйл ажиллагааг “Хог хаягдлын тухай” хууль, эрх зүйн актуудыг баримтлан ажиллах
- Үйлдвэрийн хотхоны хэсгүүдийн дагуу хог асгахад хамгийн тохиромжтой газарт хогийг ангилан ялгалт хийх боломжтойгоор савуудыг төрөлжүүлэн, байрлуулах, хаягжуулах, үүнд:
  - Аюултай хог хаягдал (химийн бодисын хаягдал )
  - Хоёрдогч түүхий эд (мод, хуванцар, төмөр, шил, хуванцар сав суулга)
  - Хүнсний хог хаягдал гэх мэт
- Хог хаягдал хаясан хөрсийг тогтмол цэвэрлэх, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх
- Хог хаягдлын булшлах цэгийг зориулалтын стандартын дагуу байгуулах
- Эрүүл ахуй, ариун цэврийн зохих шаардлага, стандартыг мөрдөх
- Хогийн сав болон хог хаях цэгийн багтаамж, хүчин чадлаас хамааруулан тогтсон графикайн дагуу хог хаягдлыг тээвэрлэн нэгдсэн цэгт хаях, хаягдлын цэгт булшлах
- Хогийг битүүмжлэл сайтай машинаар тээвэрлэх, задгай машинаар тээвэрлэх бол түүнийг битүү хучих
- Хог хаягдал зайлуулах төвлөрсөн цэгийн эргэн тойронд хашаа хамгаалалт хийх, хогийг тогтмол шууж бөөгнүүлэн түүний эзлэх талбайг нь багасгаж байх.
- Хог хаягдлыг зайлуулахад хяналт тавих, хогийг багасгах, дахин ашиглах боломжийг хайх.
- Химийн бодисын хаягдлыг зориулалтын саванд хадгалан тогтмол хугацаанд мэргэжлийн байгуулагаар устгуулах, зориулалтын газар булшлах

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

### **Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, баримтлах зарчим**

“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг тогтмол хянах, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, дэмжих зарчим баримтлан ажиллах үүрэгтэй.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд “ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн ажил болон бусад үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болз ошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай. Ингэхдээ байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дагавар, бодит байдалтай уялдуулан улам баяжуулж, сайжруулан мөрдлөг болгох хэрэгтэй.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан БОАЖЯ-д хүргүүлж дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батлуулах үүрэгтэй.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзэж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг эхний 5 жилээр тооцсон болно.

### **Эрхзүйн үндэслэл ба гол шаардлага**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

Нөгөө талаас төслийг хэрэгжүүлэгч “ГААС” ХХК нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын буюу одоогийнхоор БОАЖЯ-ны нөхөн сэргээлтийн тусгай дансанд ашиглалтын үйл ажиллагаа дуусах хүртэл жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур  
жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг төвлөрүүлнэ. Хэрвээ “ГААС” ХХК байгаль хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж, уурхайн ашиглалтын жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлсэн бол Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3-т заасан хаалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийн явцыг үндэслэн мөн хуулийн 9.10-т зааснаар хуримтлагдсан хөрөнгийг тодорхой хуваарийн дагуу буцаан олгохоор зохицуулагдсан.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ**

*Хүснэгт 16 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал*

<b>№</b>	<b>Хэрэгжүүлэх арга хэмжээ</b>	<b>Нийт зардал /мян.төг/ 2023 он</b>
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	900,0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5500.0
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1600.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1800.0
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1000.0
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	790.0
	БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
<b>Нийт</b>		<b>11590.0</b>

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

*Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө*

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Холбогдох зардал мян.төг	Хугацаа ба давтамж	Хариуцах эзэн	Гарах үр дүн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
<b>1</b>	<b>Агаар орчин</b>	-				
	Тээврийн хэрэгслүүдээс гарах хорт утааг багасгахын тулд тогтмол үзлэгт хамруулж байх	-	4-р сар	“ГААС” ХХК	Технологийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилтыг бууруулах Техникийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтыг бууруулах Бохирдлыг бууруулах	Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003
	Шатах тослох материалын хадгалалтанд хяналт тавих	-	5-11 -р сар	“ГААС” ХХК		
<b>2</b>	<b>Усны нөөц чанарыг хамгаалах чиглэлээр</b>	<b>300.0</b>				
	Үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний явцад усны алдагдлыг бууруулах, зогсоох зорилгоор ус хадгалж байгаа техник, төхөөрөмжийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж шаардлагатай тоног төхөөрөмжүүдэд засвар, шинэчлэлийг тогтмол хийж байх	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	“ГААС” ХХК	Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн биелэлт Усны нөөцийг хэмнэх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/
	Бохир усыг тогтмол халдваргүйжүүлэхэд анхаарч, хаягдлын сангийн гадна талбай, бохир усны сангийн эргэн тойрон, зах хөвөөгөөр ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ажлыг тогтмол төлөвлөж хийх	300.0	Тогтмол	“ГААС” ХХК		
<b>3</b>	<b>Хөрс, ургамлын бүрхэвч</b>	<b>500.0</b>				
	Үйлдвэр рүү очих, түүхий эд тээвэрлэх замын маршрутыг тодорхой тогтоож тэмдэгжүүлэх,	500.0	Төсөл хэрэгжих эхний жилд	“ГААС” ХХК	Хөрсний бохирдол, элэгдэл, эвдрэлийг бууруулах	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Холбогдох зардал мян.төг	Хугацаа ба давтамж	Хариуцах эзэн	Гарах үр дүн	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	Ажилчдын тосгон болон үйлдвэрийн хороонд, цэцэрлэгийн хотхон орчимд явган замаас бусад, харуулын байрны ойр орчмын талбайнуудыг зүлэгжүүлэх	Үйл ажиллагааны зардал		“ГААС” ХХК	Ногоон байгууламж бий болох Ажилчдын амьдрах таатай орчинг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>•Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага MNS 5915:2008,</li> <li>•Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах техникийн шаардлага MNS 5916:2008,</li> <li>•Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага MNS 5918:2008,</li> <li>•Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс MNS 4919: 2000,</li> <li>• Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага MNS 4920: 2000,</li> </ul>
<b>4</b>	<b>Ан амьтан</b>	<b>100.0</b>				
	Осол гарч болзошгүй цэгүүд болон хүн, амьтан, мал гардаг хэсгүүдэд тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	100.0		“ГААС” ХХК	Ан амьтныг хамгаалах, аюул ослоос урьдчилан сэргийлэх	Амьтны тухай хууль
<b>НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ /МЯН.ТӨГ/</b>		<b>900.0</b>				

**Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоол зааврын дагуу үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг төслийн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй.

Төсөл хэрэгжих талбайн орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцох зорилготойгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх нь ашигт малтмалын болон байгаль орчны хуулийн заалтыг хэрэгжүүлэх гол үндэс нь юм.

Дараах хууль актыг баримтлан хэрэгжүүлэх шаардлага тавигдана:



**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

- MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт
- MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
- MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар /БО-ы болон ХААҮ-ийн сайдын 2000 оны 64/А/62 тоот тушаалын 3-р хавсралт /

*Хүснэгт 17 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө*

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Ажлын хэмжээ, га	Хугацаа	Жилийн төсөв /мян.төг/	Хэрэгжүүлэгч
1	Бэлтгэл ажлын үед	Хаягдлын далан болон үйлдвэрийн барилгын үе шат	1,2	2023 онд	Үйл ажиллагааны зардалд	“ГААС” ХХК
2	Шимт хөрс арчилгаа	Ажилчдын байр, үйлдвэрийн байр орчимд	0,6		Үйл ажиллагааны зардалд	
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Мод тарих	-		5500,0	
<b>НИЙТ</b>					<b>5500.0</b>	

**Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Жонш баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөөнд дүйцүүлэн хамгаалах ажил хийгдэхгүй болно.

**Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө**

Жонш баяжуулах үйлдвэрийн талбайн ойр орчим нөлөөллийн бүсэд айлын өвөлжөө, хаваржаа бүхий газартай давхцаагүй учир нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох ажил хийгдэхгүй.

**Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Жонш баяжуулах үйлдвэрийн талбайд одоогоор энэ төрлийн олдвор олдоогүй.

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

*Хүснэгт 18 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

Арга хэмжээ	Эрсдлээс хамгаалах арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
-Эрсдлээс урьдчилан сэргийлэх хэмжээ арга  - Эрсдэл тохиолдох үед авах арга хэмжээ - Эрсдэл тохиолдсоны дараах үед авах арга хэмжээ	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдэл, бүрэн бүтэн байдлыг хангаж, галын хорны ашиглалтын хугацаанд хяналт тавих	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	“ГААС” ХХК	<ul style="list-style-type: none"> <li>- Аюулыг бууруулах</li> <li>- Эрсдлээс сэргийлэх</li> <li>- Эрсдлийг бууруулах</li> <li>- Дүгнэлт гаргах</li> </ul>
	Үйлдвэрийн цахилгаан дэд өртөөний монтажийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулан шалгалт хийн баримтжуулж байх	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
	Химийн бодис хадгалах байрыг анхааруулсан самбар, тэмдгийг хийж байршуулах	500.0	3 жил тутам		
	Гэнэтийн аюул ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг ажилтан, ажил-лагчдад таниулан сурталчилж, мөрдлөг болгох	100.0	Сард 1 удаа		
	Гэнэтийн ослын үед ажиллах сургалтыг мэргэжлийн албадаар хийлгэх	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
	Гал унтраах системийн бэлэн байдал, ажиллагааг шалгаж, илэрсэн гэмтэл зөрчлийг арилгах арга хэмжээ авч, бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
	Хамгаалалтын төрөл бүрийн хэрэгслийг эрсдлийн үнэлгээнд заасны дагуу байрлуулахын зэрэгцээ эрүүл мэндийн анхны тусламжийн болон бусад онцгой байдлын багаж, хэрэгслүүдийг хамгийн ойр, тохиромжтой газарт байрлуулах.	1000.0	Тогтмол		
Химийн бодисоос үүсэх эрсдлийг бууруулах	Химийн бодисуудын агуулахыг үйлдвэрийн хотхоноос тусад нь байршуулах, агааржуулагч гаргах	Үйл ажиллагааны зардал	Төслийн эхэн үе шатанд		
	Химийн бодисын сав баглаа боодлыг тусгайлан ялган байршуулах цэг төлөвлөх	Үйл ажиллагааны зардал	Төслийн эхэн үе шатанд		
	Химийн бодисын тээвэрлэлт хадгалалтын явцад савынхаа битүүлжлэлийг сайн шалгах, хянах	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
	Химийн бодисыг тээвэрлэх, түүнд ажиллах хүмүүсийг ам, нүд, бүх биеийн хамгаалалтын хувцастай байлгах	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
	Агуулах байранд орохдоо хамгаалалтын хувцастай байх	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>1600.0</b>			

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө**

*Хүснэгт 19 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

Хог хаягдлын төрөл	Арга хэмжээ	Төсөв /мян.төг/	Хугацаа ба давтамж	Хариуцах эзэн	Стандарт
Шингэн хог хаягдал	Бохир усны цооногийн дүүргэлтийг байнга шалгаж, бохир усны хэмжээ дүүрч ойр орчныг бохирдуулахаас сэргийлэн төвлөрсөн цэгт зайлуулна	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	Ер.инженер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам, Ариун цэврийн тухай хууль
	Бохир усны цооногийн ойр орчмыг хатуу хучилтай болгож, зөөвөрлөх явцад хөрсөнд нэвчихээс хамгаалах	Үйл ажиллагааны зардал	Төслийн эхэн үе шатанд		
	Усан санд хуримтлагдаж байгаа технологийн ус алдагдаж орчныг бохирдохоос сэргийлж хяналт тавих	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш		
	Химийн бодисын ашиглалтын явцад аюулгүй ажиллагааны журмыг нарийн баримтлан ажиллаж, асгар-сан тохиолдолд зохих журмын дагуу саармагжуулах	500.0	1 жилд 2 удаа		
	Машин механизмаас техникийн улсын үзлэгт жил бүр тогтмол оруулах	Үйл ажиллагааны зардал	1 жилд 1 удаа		
Ахуйн болон хатуу хог хаягдал	Үйлдвэрийн нутаг дэвсгэрт үүсэх энгийн болон техникийн хатуу хаягдлыг түр хадгалах цэгийг зохих журмын дагуу зохион байгуулах	200.0	Төслийн эхэн үе шатанд	Ер.инженер	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хаягдал усыг зайлуулах цэг тогтоох журам, Ариун цэврийн тухай хууль
	Хатуу хаягдлыг зайлшгүй ялган сортолж зохих хоёрдогч түүхий эдийн цэгт тушаах, ангилсан хаягдал агуулах нэмэлт хогийн савнууд суурилуулж тэмдэгжүүлэх	300.0	Үйл ажиллагааны турш		
	Химийн бодисын сав баглаа боодол, үлдэгдлийг тусгайлан ялгаж цуглуулан тусгай саванд хадгалж, ал-дагдахаас сэргийлэх, цаг тухайд нь зохих журмын дагуу зайлуулах	300.0	Сард 1 удаа		
	Дахин ашиглагдах боломжгүй хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зайлуулах	Орон нутагтай хийх гэрээний дагуу	Улиралд 1 удаа		
	Хог хаягдлыг тогтмол хугацаанд бөөгнүүлэн хамах, ариутгаж халдваргүйжүүлэх арга хэмжээг авах	Үйл ажиллагааны зардал	Сард 1 удаа		
	Хатуу хаягдал гадна талд бусад орчинд алдагдахаас сэргийлэх хашаа барих	500.0	Төслийн эхэн үе шатанд		
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>		<b>1800.0</b>			

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө**

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг байгаль орчны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд жил бүр гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Нөхөн сэргээлтийн болон байгаль хамгаалах ажлыг урьдчилан төлөвлөсний дагуу дэс дараалалтай хийж гүйцэтгэх,
- Компаний удирдлага нь байгаль орчны холбогдолтой бүх хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг удирдаж зохион байгуулахаас гадна хуулийн өмнө хариуцлага хүлээнэ,
- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудад хүргүүлж, тайлагнаж байх,
- Байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл (газар хөдлөлт, үер, салхи, шуурга) болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллагсдыг жилд 1 удаа сургаж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах, энэ талаар дотоод журам төлөвлөгөөтэй ажиллана,
- Хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, гал түймрийг унтраах багаж хэрэгслийг бэлтгэж, байнга бэлэн байлгах,
- Ахуйн хог хаягдлыг байнга цэвэрлэн ариутгаж байх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж байх.

*Хүснэгт 20 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

№	Удирдлага зохион байгуулалтын зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал /мян.төг/	Хугацаа ба давтамж
1	Хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх, шинэчлэн засварлах, байгаль орчны асуудал хариуцсан ажилтантай болох		Дотоод төлөвлөлтөөр	Байнга
2		Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой бэлтгэл хангуулах арга хэмжээ зохион байгуулах		500.0	2023 онд

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

3	Байгаль орчныг хамгаалах, осол аваар, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах	500.0	Жилд 1 удаа
4	Ажилчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах	Дотоод төлөвлөлтөөр	Жилд 1 удаа
5	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангах	Дотоод төлөвлөлтөөр	2023 онд
6	“Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 101-р зүйлд заасны дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Үйл ажиллагааны зардалд	2023 онд
7	Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг хуулиар тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэх	Үйл ажиллагааны зардалд	2023 онд
<b>НИЙТ</b>			<b>1000.0</b>

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь**

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

*Хүснэгт 21 БОМТ-ий хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь*

№	БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн Агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	Төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд	Хэлэлцүүлэх	БОМТ-ий хэрэгжилтийн талаар - Төслийн гүйцэтгэлийг хянаж, шалгах ба эдийн засгийн алдагдал болон бусад мэдээллийг	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Сум багийн иргэдийн хуралд
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Цаашид анхаарах асуудал	Засаг даргын тамгын газар
3	БОАЖЯ	БОМТ-ний тайлан, төлөвлөгөө-г батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12-р сарын 10-наас өмнө	Цаашид хэрэгжүүлэх ажил болон хийгдэж буй ажилд зөвлөгөө өгөх, үнэлж дүгнэх	БОАЖЯ-нд

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “ГААС” ХХК -иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

Уг төслийн үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОХТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүнийг тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “ГААС” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

*Хүснэгт 22 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Агаарын чанар</b>						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд (үйлдвэрийн агуулах, хаягдлын сан, химийн бодисыг агуулах, хаягдлын цэг)	Жилд 2 удаа	2 цэг х 60.0 = 120.0 120.0 х жилд 2 удаа = НИЙТ 240.0	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах	үйлдвэрийн ойролцоо талбайд 2 цэг	Жилд 2 удаа		
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа, хөдөлгөөнөөр шуугиан үүсэх	Хүнд даацын машины тээврийн зам, бутлуур цех үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим 2 цэгт	Жилд 2 удаа	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2 удаа НИЙТ 60.0	
<b>Хөрсний бохирдол</b>						

**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловсруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Үйлдвэрийн талбайн доторхи 4 цэгээс (үйлдвэрийн орчим, хаягдлын далан, ажилчдын байр, химийн бодисын агуулах)	Жилд 1 удаа	2 цэгт х 2 дээж х жилд /25.0/ НИЙТ 100,0 /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж - 25.0 төг,	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Хүнд металлын агууламж	Түлш, тосолгооны материал болон химийн бодис, хог хаягдлаар хөрс бохирдох		Жилд 1 удаа	2 цэгт х 2 дээж х 30,0 НИЙТ 120.0 /хүнд металлын шинжилгээ 1 дээж- 30.0 төг/	
<b>Усны хяналт шинжилгээ</b>						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хүнд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Унд ахуйн усыг хангаж буй гүний худаг 3 ш	Жилд 1 удаа	НИЙТ 120.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
2.2	Усны бохирдол, усны түвшний өөрчлөлт	Газрын доорхи болон хөрсний усны түвшин, бохирдол	Хаягдлын орчимын хяналтын худаг	Жилд 1 удаа	НИЙТ 50.0	
<b>Ургамал, амьтны аймаг</b>						



**“ГААС” ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших “Хайлуур жонш боловруулах үйлдвэр” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
3.1	Ургамал устгах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биомасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт	Жилд 1 удаа	НИЙТ 100.0	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
<b>Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 2023 оны зардлын дүн</b>					<b>790.0</b>	



## Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын/Journal No: 000471614926

Системийн огноо/System Date: 2023.06.09 13:09:05

Дт/From	Дансны/Картын дугаар Account/Card number 5163189040	Нэр/Name ГААС	Дүн/Amount 5,800,000.00 MNT	Ханш/Rate 1.00
/ Таван сая найман зуун мянган төгрөг /				
Кт/To	Банкны дугаар/Branch No 90 Дансны/Картын дугаар Account/Card number 100900013406	Банкны нэр Bank Name Төрийн Сан Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	Дүн/Amount 5,800,000.00 MNT	Ханш/Rate 1.00

Гүйлгээний утга/Transaction description:

ЕВ-5460816 ГААС Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа